



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/705

Есөнбулаг

Арга хэмжээний тов, байршил
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хүний бүхий л цаг үеийн оюуны цуглуулга охь дээж, бахархал омогшил болсон ирээдүйг заагч "Жангар" туулийг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Туульсын хаан Жангар" эвент арга хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 21-ний өдөр Алтай хотод, "Жангар" монгол туургатан залуучуудын фестивалийг 07 дугаар сарын 22-ны өдөр Хөхморьт сумын Дөргөн нууранд зохион байгуулж байхаар тогтоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

